

## ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

### ХАРИЛЦАН ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД, ХОЛБОГДОХ ЭТГЭЭД, ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмын зорилго нь харилцан хамаарал бүхий этгээдийг тодорхойлох, банкнаас холбогдох этгээдтэй харилцахад баримтлах зарчим, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлээр тодорхойлсон хязгаарлалтын биелэлтийг тооцох, тайлагнах, хяналт тавих арга, аргачлал, том харилцагч, төвлөрлийн эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Банк аливаа этгээд, түүний харилцан хамаарал бүхий этгээд, холбогдох этгээдтэй Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлага, холбогдох бусад хууль, тогтоомж болон энэ журмыг удирдлага болгон хамтран ажиллана.
- 1.3. Банк аливаа этгээд, түүний харилцан хамаарал бүхий этгээд, холбогдох этгээдтэй шударга, ижил тэгш, аливаа дарамт шахалтаас ангид (arm's length transaction) хэлбэрээр харилцана.
- 1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.4.1. “Үлдэгдэл” гэж эрсдэлийн сан, хямдруулалт, урамшуулал, дахин үнэлгээ, бодит үнийн залруулга, хойшлогдсон төлбөрийн тохируулга хийгдээгүй тэнцлийн дансанд бүртгэгдсэн активын хэмжээг;
  - 1.4.2. “Дүн” гэж эрсдэлийн сан, эх үүсвэр, бусад тохируулга хийгдээгүй тэнцлийн гадуур дансанд бүртгэгдсэн хүлээж болзошгүй үүргийн хэмжээг;
  - 1.4.3. “Өөрийн хөрөнгө” гэж энэ журмын 4.1 дэх хэсэгт заасныг.
  - 1.4.4. “Зээлдэгчийн актив” гэж энэ журмын 4.2 дахь хэсэгт заасныг.
  - 1.4.5. “Холбогдох этгээд” гэж гэж Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт тодорхойлсоныг,

#### ХОЁР. ХАРИЛЦАН ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД

- 2.1. Харилцан хамаарал бүхий этгээд нь хөрөнгийн өмчлөл, удирдлага болон санхүү, үйл ажиллагааны хувьд хамаарал бүхий гэсэн хоёр хэлбэртэй байна.
- 2.2. Дараах нөхцөлүүдийн аль нэг биелсэн тохиолдолд гуравдагч этгээдийг хөрөнгийн өмчлөл, удирдлагын хувьд тухайн этгээдтэй харилцан хамааралтай гэж үзнэ. Үүнд:
  - 2.2.1. Нэгдлийн оролцогч бол;

- 2.2.2. Тухайн этгээд гуравдагч этгээдийн саналын эрхтэй хувьцааны таваас илүү хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг бол;
  - 2.2.3. Тухайн этгээд гуравдагч этгээдийн эрх бүхий албан тушаалтанг томилох, чөлөөлөх, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулахад шууд болон шууд бусаар нөлөөлөх чадвартай бол;
  - 2.2.4. Тухайн этгээд гуравдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, шийдвэрт шууд болон шууд бусаар нөлөөлөх чадвартай бол.
- 2.3. Дараах нөхцөлүүдийн аль нэг биелсэн тохиолдолд гуравдагч этгээд санхүү, үйл ажиллагааны хувьд тухайн этгээдтэй харилцан, хамааралтай гэж үзнэ. Үүнд:
- 2.3.1. Тухайн этгээдийн үйл ажиллагаа доголдох, төлбөрийн чадваргүй болох, татан буугдахад гуравдагч этгээдийн үйл ажиллагааг доголдох, төлбөрийн чадваргүй болох, татан буугдах бол;
  - 2.3.2. Тухайн этгээдээс гуравдагч этгээдийн жилийн нийт орлого эсвэл ажил, үйлчилгээний 50 ба түүнээс их хувь хамаардаг бол;
  - 2.3.3. Тухайн этгээд гуравдагч этгээдийн өр төлбөрт баталгаа, батлан даалт гаргасан бол;
  - 2.3.4. Тухайн болон гуравдагч этгээдүүдийн зээл төлөх эх үүсвэр ижил бол;
  - 2.3.5. Тухайн этгээд зээл авах, санхүүжилт босгох чадваргүй болоход гуравдагч этгээд зээл авах, санхүүжилт босгох чадваргүй болох бол.
- 2.4. Тухайн этгээдийн харилцан хамаарал бүхий этгээдийг таних, илрүүлэх арга хэмжээг банк хэрэгжүүлнэ.
- 2.5. Нэг зээлдэгчийн актив банкны өөрийн хөрөнгийн 0.25 хувиас бага бол түүнийг аливаа этгээдийн харилцан хамаарал бүхий этгээд гэж үзэхгүй байж болно.

### **ГУРАВ. ХОЛБОГДОХ ЭТГЭЭДТЭЙ ХАРИЛЦАХ**

- 3.1. Банкны тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт тусгасан болон тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих, өгөөж хүртээх зорилгоор гуравдагч этгээдтэй хийж буй бизнесийг холбогдох этгээдтэй хийх хэлцэл гэнэ.
- 3.2. Банк холбогдох этгээдтэй хийх хэлцэл харилцан ашигтай, аливаа дарамт шахалт, нөлөөнөөс ангид байна.
- 3.3. Банкнаас холбогдох этгээдтэй харилцах бодлого, журам, зарчим тогтоох, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах нь банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн (цаашид ТУЗ гэх) үүрэг байна. Ингэхдээ дараах ажил үүргийн хуваарийг баримтлана. Үүнд:
  - 3.3.1. ТУЗ-ийн ажлын алба холбогдох этгээд, түүнд холбогдох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын талаарх мэдээллийн санг хариуцаж, хууль тогтоомжийн дагуу тухай бүр шинэчлэн, Монголбанкинд ирүүлнэ;

- 3.3.2. Ажлын албанд холбогдох этгээдийн мэдээлэл хүргүүлэх ажилтан, хөрөнгө оруулагч, бусад этгээдийн жагсаалт, хугацаа, давтамжийг ТУЗ тогтооно;
  - 3.3.3. Аудитын асуудал эрхэлсэн хороо банкнаас холбогдох этгээдтэй харилцах бодлого, журам, зарчмын хэрэгжилт, бүртгэлийн үнэн зөв, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тайланг хагас жил тутам ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ;
  - 3.3.4. Гүйцэтгэх удирдлага холбогдох этгээдтэй хийж буй бизнесийн үйл ажиллагааны тайланг хагас жилд тутам ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 3.4. Холбогдох этгээдийн хэлцэл нь зээлийн (*exposure*) болон зээлийн бус (*non-exposure*) хэлбэртэй байна.
- 3.5. Холбогдох этгээдийн зээлийн хэлцэлд дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:
- 3.5.1. Зээл, авлага, зээлтэй адилтган тооцох актив үүсгэх, худалдан авах;
  - 3.5.2. Бүх төрлийн өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх, түүнтэй адилтгах үнэт цаас худалдан авах, хөрөнгө оруулах;
  - 3.5.3. Бүх төрлийн баталгаа, батлан даалт, зээлийн шугам, аккредитив, бусад хүлээж болох үүрэг үүсгэх, худалдан авах;
  - 3.5.4. Активыг эрсдэлийн сангаас хаах.
- 3.6. Холбогдох этгээдийн зээлийн хэлцэл дараах зарчимд нийцсэн байна. Үүнд:
- 3.6.1. Бизнесийн хувьд ашигтай;
  - 3.6.2. Цаг хугацааны хувьд тохиромжтой;
  - 3.6.3. Хэлцлийн шаардлага, хүү, нөхцөл нь ердийн харилцагчдад тавих шаардлага, хүү, нөхцөлтэй ижил;
  - 3.6.4. Хэлцлээс учирч болох эрсдэлийг зөв тодорхойлсон.
- 3.7. Холбогдох этгээдийн зээлийн бус хэлцэлд дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:
- 3.7.1. Эх үүсвэр татах, байршуулах, хүү төлөх, төлүүлэх;
  - 3.7.2. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл хийх;
  - 3.7.3. Хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, худалдах, түрээслүүлэх, түрээслэх;
  - 3.7.4. Мэргэжлийн зөвөлгөө авах, өгөх;
- 3.8. Холбогдох этгээдийн зээлийн бус хэлцэл дараах зарчимд нийцсэн байна. Үүнд:
- 3.8.1. Хэлцлийн шаардлага, хүү, нөхцөл нь ердийн харилцагчдад тавих шаардлага, хүү, нөхцөлтэй ижил;
  - 3.8.2. Цаг хугацааны хувьд тохиромжтой;
  - 3.8.3. Хэлцлийн бодит хэрэгцээ, шаардлага үүссэн;
  - 3.8.4. Хэлцлийн зардал, хөлс, үнэ нь зах зээлийн жишигт нийцсэн;
  - 3.8.5. Ханган нийлүүлэгчийг нээлттэй, ил тод, өрсөлдөөний зарчмаар сонгосон.

3.9. Энэ журмын 3.6 болон 3.8 дахь хэсэгт заасан зарчимтай нийцээгүй хэлцэл нь Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийг 17.9 дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр бус байна.

3.10. Холбогдох этгээдтэй дараах хэлцэл хийхийг хориглоно. Үүнд:

3.10.1. Холбогдох этгээдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив өгөх;

3.10.2. Холбогдох этгээдээс шууд болон шууд бусаар хөрөнгө, үйлчилгээ худалдан авч тус эх үүсвэрээр банкны авлагыг барагдуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх.

3.11. Холбогдох этгээдийн хэлцлийг дараах жишгийг үндэслэн шийдвэрлэнэ.

<i>Хэлцлийн хэмжээ</i>	<i>Шийдвэр гаргах субъект</i>
Үлдэгдэл (Дүн) $\geq$ ӨХ-ийн 3%	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ӨХ-ийн 3% $>$ Үлдэгдэл (Дүн) $\geq$ ӨХ-ийн 1%	ТУЗ-ийн хурал
Үлдэгдэл (Дүн) $<$ ӨХ-ийн 1%	Гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан

ӨХ-Өөрийн хөрөнгө

3.12. Банк дотооддоо энэ журмын 3.10 дахь хэсэгт тусгасан нөхцөлөөс хатуу жишиг тогтоон мөрдүүлж болно.

3.13. Холбогдох этгээд өөрт хамаарах хэлцлийг шийдвэрлэх хурал, үйл явцад саналын эрхтэй оролцохыг хориглоно.

3.14. Дараах тохиолдолд холбогдох этгээдийн хэлцэл гэж үзэхгүй байж болно. Үүнд:

3.14.1. Тухайн холбогдох этгээдийн нийт хэлцлийн үлдэгдэл болон дүнгийн нийлбэр 40 сая төгрөгөөс бага;

3.14.2. Банкинд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй удирдах шатны ажилтнаас бусад ажилтны цалингийн зээл;

3.14.3. Холбогдох этгээдэд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй удирдах шатны ажилтнаас бусад ажилтны цалингийн зээл.

## **ДӨРӨВ. ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТООЦОХ**

4.1. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд тусгасан төвлөрлийн хязгаарлалтын биелэлтийг тооцоход ашиглагдах өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

4.1.1. Монголбанк, Сангийн яамнаас хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн багц материалын дагуу банкны бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө;

4.1.2. Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны зохицуулалтын дагуу эрсдэл даах чадвартай эх үүсвэр.

4.2. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт тусгасан хязгаарлалтын биелэлтийг тооцоход ашиглах аливаа этгээд, түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн актив дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 4.2.1. Зээл, авлагын үлдэгдэл;
- 4.2.2. Өрийн бичиг, хувьцааны үлдэгдэл;
- 4.2.3. Аккредитив, баталгаа, батлан даалтын нийт дүнгийн 50 хувь;
- 4.2.4. Зээлийн шугамын ашиглаагүй дүн;
- 4.2.5. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн цэвэр авлага.

4.3. Аливаа этгээд, түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн активт дараах тохируулгуудыг хийнэ. Үүнд:

- 4.3.1. Актив нь Монгол Улсын Засгийн газрын баталгаа, олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А”-аас доошгүй үнэлгээ бүхий санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;
- 4.3.2. Актив нь Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банкнаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;
- 4.3.3. Актив нь дотоодын банк, Монгол Улсын Хөгжлийн банктэй эрсдэл хуваах нөхцөлтэй (*syndicated loans гэх мэт*) бол харгалзах дүнгээр тухайн банкны активыг цэвэршүүлж, эрсдэл хуваагч банкны активыг нэмэгдүүлнэ;
- 4.3.4. Актив нь Монголбанкнаас баталсан банкны активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах журмын дагуу хугацааны үзүүлэлтээр хэвийн бус, эргэлзээтэй, муу ангилалд бүртгэгдсэн бол харгалзах тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлнэ;
- 4.3.5. Актив нь үл маргах журмаар цэвэршүүлэх (*netting arrangement*) нөхцөлтэй эх үүсвэрээр баталгаажсан бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;
- 4.3.6. Активын барьцаа нь Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын баталгаатай үнэт цаас, Төв банкны үнэт цаас бол барьцааны үнэлгээгээр цэвэршүүлнэ;
- 4.3.7. Зээлдэгчийн төлбөрийн чадвар алдагдах эрсдэл үүссэн үед банкны санаачилгаар шууд хаагдах нөхцөлтэй зээлийн шугамын ашиглаагүй үлдэгдлийг цэвэршүүлнэ;
- 4.3.8. Банк хоорондын өдрийн зээл, овернайт зээлийн тэнцлийн үлдэгдлийг тооцоонд оруулахгүй;
- 4.3.9. Монголбанкнаас зөвшөөрсөн бусад тохируулга.

4.4. Дараах нөхцөлүүдийн аль нэг биелсэн тохиолдолд зээлүүдийг нэгтгэж, энэ журмын 4.2 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтад хамруулна. Үүнд:

- 4.4.1. Шинээр олгосон зээлийг банкны өөр зээлдэгчид дамжуулан зээлдүүлсэн бол;
- 4.4.2. Нэг төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зориулалттай зээлүүдийг;
- 4.4.3. Шинээр олгосон зээлийн ашиглалт нь банкны өөр зээлдэгчийн үйл ажиллагааг шууд дэмжих зориулалттай бол.

- 4.5. Дараах тохиолдолд Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт тусгасан хязгаарлалтыг хангах хуанлийн 30 хоногийн хугацааг банкинд өгнө. Үүнд:
- 4.5.1. Энэ журмаар тодорхойлсон том зээлдэгчийн активын чанар муудаж, тусгай эрсдэлийн сан байгуулснаар банкны өөрийн хөрөнгө буурч, хязгаарлалт хангахгүй болсон (*эрсдэлийн сан байгуулсан өдрөөс*);
  - 4.5.2. Зээлдэгчдийн дунд шинээр харилцан хамаарал бий болсны улмаас хязгаарлалт хангахгүй болсон (*харилцан хамаарал бий болсон өдрөөс*);
  - 4.5.3. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалд өөрөөр заагүй бол өөрийн хөрөнгийн тодорхойлолт өөрчлөгдсөний улмаас хязгаарлалт хангахгүй болсон (*тушаал гарсан өдрөөс*);
  - 4.5.4. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалд өөрөөр заагүй бол Монголбанкны шийдвэрээр бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд бусад банкнаас актив шилжүүлэн авсны улмаас хязгаарлалт хангахгүй болсон (*тушаал гарсан өдрөөс*).
- 4.6. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтын биелэлтийг тооцоход ашиглагдах баталгаа, батлан даалт нь дараах бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ журмын 4.3 дахь хэсэгт тусгасан тохируулгыг хийнэ. Үүнд:
- 4.6.1. Экспорт, импорт, худалдааны баталгаа, факторинг, батлан даалт, аккредитивын дүн;
  - 4.6.2. Урьдчилгаа төлбөрийн баталгаа, батлан даалтын дүн;
  - 4.6.3. Векселийн баталгаа, батлан даалтын дүн;
  - 4.6.4. Тендер болон гүйцэтгэлийн баталгаа, батлан даалтын дүн;
  - 4.6.5. Банкнаас гаргасан бусад баталгаа, батлан даалтын дүн.
- 4.7. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтын биелэлтийг тооцоход ашиглагдах холбогдох этгээдийн актив дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
- 4.7.1. Холбогдох этгээдэд олгосон зээл, авлагын үлдэгдэл;
  - 4.7.2. Холбогдох этгээдийн бүх төрлийн өрийн хэрэгслийн үлдэгдэл;
  - 4.7.3. Холбогдох этгээдийн хувьцааны үлдэгдэл;
  - 4.7.4. Холбогдох этгээдэд гаргасан баталгаа, батлан даалт, аккредитив, түүнтэй адилтгах бусад хүлээж болзошгүй үүргийн дүн;
  - 4.7.5. Холбогдох этгээдэд гаргасан зээлийн шугамын ашиглаагүй дүн;
  - 4.7.6. Холбогдох этгээдтэй байгуулсан санхүүгийн үүсмэл хэрэгслийн банкны авлага талын дүн;
  - 4.7.7. Холбогдох этгээдэд зээлдүүлэх, ашиглуулах, үйл ажиллагааг нь дэмжих, өгөөж хүртээх зорилгоор гуравдагч этгээдэд байршуулсан хөрөнгө, өрийн хэрэгсэл, хувьцааны үлдэгдэл;
  - 4.7.8. Холбогдох этгээдийн үйл ажиллагааг дэмжих, өгөөж хүртээх зорилгоор гуравдагч этгээдэд гаргасан баталгаа, батлан даалт, аккредитивын дүн;
  - 4.7.9. Холбогдох этгээдээс бараа, үйлчилгээ худалдан авахад зориулан гуравдагч этгээдэд олгосон зээл, өрийн хэрэгсэл, хувьцаа, хөрөнгө оруулалтын үлдэгдэл;

- 4.7.10. Холбогдох этгээдтэй хийсэн хэлцлээс банкинд үүссэн, цаашид үүсч болзошгүй алдагдал, алдагдсан боломжийн нийлбэр:
- 4.7.10.1. Эх үүсвэр байршуулснаас, татан төвлөрүүлснээс; (*хэлцлийн хугацаанд*)
  - 4.7.10.2. Хөрөнгө түрээсэлснээс, түрээслүүлснээс; (*түрээсийн хугацаанд*)
  - 4.7.10.3. Хөрөнгө, бараа, үйлчилгээ худалдсанаас, худалдан авснаас; (*гэрээ байгуулснаас хойш 1 жилийн хугацаанд*)
- 4.8. Холбогдох этгээдийн активт дүнд энэ журмын **4.3.1, 4.3.2** дахь хэсэгт тусгасан тохируулгыг хийж болно.
- 4.9. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1 дэх хэсэгт тусгасан хязгаарлалтын биелэлтийг тооцоход ашиглагдах үнэт цаас дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
- 4.9.1. Хуулийн этгээдийн өрийн хэрэгслийн үлдэгдэл;
  - 4.9.2. Хуулийн этгээдийн гаргасан векселийн үлдэгдэл;
  - 4.9.3. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаас гэж үзсэн бусад хэрэгсэл.
- 4.10. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.2 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтын биелэлтийг тооцоход ашиглагдах хувьцаа нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
- 4.10.1. Компанийн хувьцааны тэнцлийн үлдэгдэл;
  - 4.10.2. Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрхийн тэнцлийн үлдэгдэл;
  - 4.10.3. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хувьцаа гэж үзсэн бусад хэрэгсэл.
- 4.11. Холбогдох этгээдэд хамаарахгүй үнэт цаас, хувьцаанд энэ журмын **4.3** дахь хэсэгт тусгасан тохируулгыг хийнэ.
- 4.12. Энэ журмын **4.110** дахь хэсэгт заасан хязгаарлалтын биелэлтийг тооцоход Монголын банкны холбооны хувьцааг хамруулахгүй.
- 4.13. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтыг тооцоход Монголын ипотекийн корпорацийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас хамаарахгүй бөгөөд холбогдох этгээдэд хамаарахгүй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд энэ журмын **4.3** дахь хэсэгт тусгасан тохируулгыг хийнэ.
- 4.14. Банк Банкны тухай хуулийн 17.1-17.5-т заасан хязгаарлалтыг хэтрүүлсэн бол уг хэтрүүлсэн дүнгийн 75 хувийг тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс тус тус хасч, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны биелэлтийг тооцно.

**ТАВ. БАНКНЫ ТОМ ХАРИЛЦАГЧ, ТӨВЛӨРЛИЙН  
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

- 5.1. Зээлдэгчийн актив, банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтэрсэн бол түүнийг том зээлдэгч гэж үзнэ. Том зээлдэгчдэд олгох активын нийлбэр өөрийн хөрөнгийн 300 хувиас хэтэрч болохгүй.
- 5.2. Монголбанк банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, эрсдэлийг харгалзан энэ журмын 5.1 дэх заалтыг ялгаатай тогтоож болно.
- 5.3. Банк өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдсан том харилцагч, тэдгээрийн актив, эх үүсвэртэй холбогдох харилцааг зохицуулсан бодлого, журамтай байна.
- 5.4. Энэ журмын 5.3 дахь хэсэгт дурдсан журамд дараах зохицуулалтыг заавал тусгана. Үүнд:
  - 5.4.1. Том харилцагчийн тодорхойлолт;
  - 5.4.2. Эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг, хариуцлага;
  - 5.4.3. Том активыг шийдвэрлэх зарчим, хийгдэх судалгаа, шинжилгээний арга аргачлал;
  - 5.4.4. Том активтай холбоотой давхар, дараалсан хяналтын тогтолцоо;
  - 5.4.5. Том активын чанар, зээлийн ашиглалтанд хийх хяналт, түүний хугацаа, давтамж, зарчим;
  - 5.4.6. Том актив, эх үүсвэрээс банкны хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болох эрсдэлийг тодорхойлох арга, аргачлал;
  - 5.4.7. Том актив, эх үүсвэрийг мэдээлэх, тайлагнах зарчим;
  - 5.4.8. Том харилцагчид үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал.
- 5.5. Журамд тусгаагүй хөнгөлөлт, чөлөөлөлт, давуу талыг том харилцагчид олгохыг хориглоно.
- 5.6. Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа агентлаг, Монгол Улсын Хөгжлийн банк, дотоодын банк, санхүүгийн байгууллага, Хадгаламжийн даатгалын корпораци том харилцагчид тооцогдохгүй.
- 5.7. Дараах тохиолдолд үйл ажиллагааны хэм хэмжээ тогтоох, зохистой харьцааг чангаруулах болон Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд тусгасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч болно. Үүнд:
  - 5.7.1. Зээл, активын харьцаа 70 хувиас хэтэрсэн;
  - 5.7.2. Хамгийн их төвлөрөлтэй 3 салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 50 хувиас хэтэрсэн;
  - 5.7.3. Гадаад валютын зээлийн нийт зээлд эзлэх хувь 30 хувиас хэтэрсэн;
  - 5.7.4. Гадаад валютын эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь 45 хувиас хэтэрсэн;
  - 5.7.5. Хугацаатай хадгаламж, Монголбанкнаас бусад санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үнэт цаас, өрийн бичгийн нийлбэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь 70 хувиас хэтэрсэн;
  - 5.7.6. Хамгийн том (нэгдсэнээр) 10 эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь 50 хувиас хэтэрсэн;



- 5.7.7. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь **40** хувиас хэтэрсэн;
- 5.7.8. Богино хугацаат (*30 хоног хүртэл*) актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны зөрүү хасах **30** хувиас хэтэрсэн.
- 5.8. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл нь энэ журмын 5.8 дахь хэсгээр хязгаарлагдахгүй.
- 5.9. Энэ журмын 5.7.5 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтыг системийн нөлөө бүхий банкинд тооцохгүй байж болно.

### **ЗУРГАА. ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

- 6.1. 40 том зээлдэгчийн активын мэдээг Хавсралт № 1-ийн дагуу Монголбанкинд сар бүрийн -ний дотор ирүүлнэ.
- 6.2. 40 том холбогдох этгээдийн активын мэдээг Хавсралт № 2-ын дагуу Монголбанкинд сар бүр ирүүлнэ.
- 6.3. 40 том эх үүсвэрийн мэдээг Хавсралт № 3-ын дагуу Монголбанкинд сар бүр ирүүлнэ.
- 6.4. Холбогдох этгээдийн мэдээллийг Хавсралт № 4-ийн дагуу Монголбанкинд тухай бүр ирүүлнэ.
- 6.5. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-17.5 дахь хэсэгт тусгасан хязгаарлалтын биелэлтийг Хавсралт № 5-ын дагуу Монголбанкинд сар бүр ирүүлнэ.
- 6.6. Энэ журмын хэрэгжилтэнд Монголбанк хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд банкинд холбогдох үүрэг, даалгавар өгөх, хууль, тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авна.
- 6.7. Энэ журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Банкны тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ноогдуулна.